



Улсын Хүн Амын Тооллого Явуулах Мэдэгдэл

Япон улсын засгийн газар нь 2010 оны 10 сарын 1 ний өдрөөс эхлэн Хүн Амын Тооллого явуулна.

Үндэсний Хүн Амын Тооллого нь хуулин дээр үндэслэгдсэн статистикийн судалгаа бөгөөд иргэншлээс үл хамааран Япон улсад амьдарч буй бүх хүмүүсийг хамруулан албадан оролцуулна.

Бөглөсөн тооллогын маягт нь гадаад иргэдийн хэрэг эрхлэх газар (цагаачлалын алба) болон цагдаагийн газарт огт ашиглагдахгүй болно.

9 сарын сүүлээр хүн амын тооллогын ажилтан тооллогын маягт тараахаар таны гэрт очно.

Улсын Хүн Амын Тооллогын үр дүн нь гадаад улсын иргэн хэн боловч амьдрахад таатай нөхцөл бүрдүүлэх бодлогын үндсэн өгөгдөл болдогт оршино.

Улсын Хүн Амын Тооллого
2010 оны 10 сарын 1 ний өдөр

